

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АЛТАЙ НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН  
/ТОВЧЛОЛ/

2019.05.05

Есөнбулаг сум  
Жаргалант баг

ИНЕГ-ын даргын баталсан 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ИНЕГ-ын харьяа Говь-Алтай аймаг дахь Алтай нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 19/07 тоот Удирдамжийн хүрээнд 2019 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийг хүртэлх хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа, Ц.Цацрал нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Говь-Алтай аймаг дахь Алтай нисэх буудлын 2017 он, 2018 оны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, нисэх буудлын даргын гаргасан тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэл, хүний нөөц бүрдүүлэлт, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, анхан шатны баримт бүрдүүлэлт, худалдан авалт, цалин хөлсний бодолт, олголт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга аван ажиглалаа.

Говь-Алтай аймаг дахь Алтай нисэх буудлын 2016-2017 оны үйл ажиллагааны үр дүнд аудитын шалгалт, 2018 оны үйл ажиллагаанд нийцлийн аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн ба 2018 оны санхүүгийн аудитын шалгалтаар “зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

Алтай нисэх буудлын даргын 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/02 дугаар тушаалаар ажилчдын хувийн хэргийг бүрдүүлэх, 2017 он, 2018 онд нисэх буудлын даргын гаргасан тушаалын биелэлтийг гаргах ажлын хэсэг байгуулан зохион байгуулалт хийснээр ажилтнуудын хувийн хэргийн бүрдүүлэлт, эмхлэлт, цэгцлэлт маш сайн болсон байна.

Нислэгийн удирдагчаар ахлуулсан орон тооны бус дотоод хяналтыг ажиглуулж байгаа нь үр дүнгээ өгсөн байна. Дотоод хяналтын ажилтанд захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд анхаарах асуудлын талаар зөвлөгөө өглөө.

Хамт олны хоорондын харилцаа найрсаг, зөрчилдөөнгүй. Удирдлагын хувьд санаачилгатай, бүтээлч, залуу боловсон хүчин байна.

Өртөг зардал хэмнэх, өөрсдийн нөөц бололцоог ашиглах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж санаачилгатай ажиллаж байна.

Цалин хөлс, түүнтэй адилтгах бусад мөнгөн тооцоогоор цалин дутуу бодож олгосон зөрчил гарсан.

Хоолны үнийн хөнгөлөлтийн тооцоогоор цалинтай чөлөө авсан ажилтнуудад хоолны мөнгө илүү олгосон.

Архивын баримтын хадгалалт хамгаалалт, үдэлт цэгцлэлт хангалтгүй, архив бичиг хэргийн хөтлөлтийн заавар, стандартыг мөрдөж ажиллагаагүй.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хангаж ажиллахад анхаарч, хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх шаардлагатай.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар тус нисэх буудалд 7 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА